

ХАШГИРААН

С. Байгалсайхан *

Одоогоос 300 гаруй жилийн өмнө Германы гүн ухаантан, математикч Готтфрид Вильгельм Лейбниц “Бид аливаа зүйлсийг ижил замаар танин мэддэггүй. Цөөн зүйлсийг мөн чанарыг шууд ойлгох замаар харин ихэнх зүйлсийг туршлагаар танин мэддэг” гэж хэлсэн байдаг. Ингэж хэлэхдээ ертөнц дэх бүх зүйлс тодорхой ойлголттой байдаг. Энэхүү ойлголт нь юмсын өөр үзэгдэлтэй холбогдох холбоо болон бүх үнэнийг агуулдаг. Энэхүү холбоог рациональ сэтгэлгээгээр дамжуулан анализ хийдэг. Энэхүү анализ нь төгсгөлтэй бол эцсийн үнэн буюу оюун ухааны үнэн, төгсгөлгүй бол туршлагаар дамжуулан эцсийн үнэнд хүрэх буюу баримтын үнэн гэж тодорхойлсон байдаг. Тодорхой шинжлэх ухаанд Пифагорийн теором, Ньютоны таталцлын хууль, Архимедийн хөшүүргийн хууль мэт танин мэдэхүйн үнэнүүд нь олон зуун жил өнгөрсөн ч үнэ цэнээ алдалгүй практикт хэрэглэгддэгийн нэгэн адил оюун ухааны хүрээнд олон нээлт амжилтууд нь өнөөдөр бидний хэрэгцээнд хэрэглэгдэж буй олон чухал түлхүүр болж байгаагийн жишээ нь эхэлж дурдсан Лейбницийн оюун ухааны болон баримтын үнэний тухай гүн ухааны сургаал юм. Энэхүү сургаал ёсоор эцсийн үнэн буюу оюун ухааны үнэнийг Бурхан л шууд хэлж өгдөг бусад тохиолдолд материаллаг ч бай, хийсвэр ч бай туршлагаар дамжуулан баримтын үнэнийг тогтоодог ажээ. Энэ гүн ухааны суурь ойлголт, сургаал бидний амьдралд, ялангуяа утга соёлд ямар холбоотой вэ гэдэг асуултад дараах зүйлээр тайлбарлая гэж бодож байна.

XX зууны утга соёл түүн дотроо уран зохиолын үнэт зүйлсийг коммунист үзэл сурталаар тодорхойлж бүхэл бүтэн зуун жил амьдарсан ард түмний соёлыг үгүйсгэх хандлага өнөөдөр хүчтэй болж оронд нь өөрсдийгөө туг мэт мандуулан ярьж бичих нь хэрээс хэтэрч бүтээж туурвиж байгаа нь ч түүнийг судлан шүүмжилж ярьж хэлж байгаа нь ч юунд тулгуурласан, юуны төлөө, ямар зорилготой нь учир үл ойлгогдох байдал нэгэнт үүсээд байгааг бид бүгдээрээ мэдэж байгаа. Ерээд оноос хойш уран зохиолын хүнд ачааг үүрч явах том хэмжээний туульсын зохиол, роман тууж багагүй хэвлэгдэн гарсан ч судлаач шүүмжлэгч сонирхогч хэн хүний сэтгэлд бууж сонирхлыг татаж утга зохиолын хөгжил хөдөлгөөнд дорвитой нэмэр нөөлөг болсон нь бараг үгүй юм. Ийм зохиолуудыг хүчээр албадан гаргах гэсэн ойлголт ч байхгүй. Гагцхүү бидний дээр өгүүлсэн туршлагаар дамжсан сэтгэлгээний эрэлхийлэл тодорхой цаг хугацааг даван туулж үр дүнд хүрдэгийг бид наяд оны дундуур багшийн мэргэжил эзэмшсэн зураач, сэтгүүлч, яруу найрагч гурван залуугийн бичсэн иргэн, төр, шашны гурвалсан роман

* МУИС-ийн Улаанбаатар сургууль

илрэхийлж өглөө гэж бодож байна. Ж.Саруулбуянгийн “Хэрлэн тэнүүн”\2008\, До.Цэнджавын “Цагаагчин гахай жил”\2011\, Г.Мэнд-Оёогийн “Тэгээнтэн”\2012\ романиуд нь хүний амьдралын цаг хугацааны хувьд зайтай боловч, улс үндэстний хөгжлийн түүх, нийгмийг хамрах цар хүрээгээрээ нэгэн цаг үед нэгдэн нийлж монгол үндэстний тухай, шашин, төр, иргэний гурвалсан холбооны тухай үүгээр дамжуулж монгол хүний, үндэстний соёл зан заншил, төрт ёс, тэдгээрийн утга учир, залгамжлан авах, хадгалагдан үлдэх гайхамшигт үйлийн тухай чухамхүү эдгээр нь бидний өв, нандигнах хадгалж хамгаалах ёстой зүйл, эдгээрийн тухай уран зохиолд үзүүлэх нь соёлын үнэт зүйлс болох тухай дүрслэн үзүүлсэн нь одоо бид хаана байгаа, юу нь зөв, юу нь буруу гэдгээ үл ухааран зөвхөн хувийн ухамсар, уншсан харсан зүйлийн хэмжээгээр бүхнийг хэмжиж үүнийгээ бүх нийтийн мэт болгон харагч, яригч, тэр орчинд амьдарч буй бусад хүмүүст харангын дуу хадаасан хашгираан болж өглөө. Хашгирааны утга учир нь урьд нь байсан, одоо байгаа, цаашид ч байх монголын гэх өвөрмөц тодотголтой реалист дүрслэл юм. Ингэж хэлэхийн бас нэгэн нотолгоог дэлхийн сонгодог урлагийн жишээг татан баталж болж байна. Өнөөгөөс зуу гаруй жилийн “Бүжиг” хэмээх зургаараа импрессионист урсгал чиглэлийг үндэслэгч Францын зураач Анри Матисс зургийнхаа өгүүлэмж дүрслэлийг Оросын нэрт хөгжмийн зохиолч Игорь Стравинскийн “Тэгээн хаврын ёслол” балетийн “Залуу охидын бүжиг”-ээс санаа авсан бол Кубизмын нэрт төлөөлөгч Пабло Пикассо “Авиньоны залуу бүсгүйчүүд” хэмээх шуугиан тарьсан зургаа өөрийн нууц амраг Фернанда Одивьегийн холбооноос үүтгэн гаргасан, таван зуун жилийн тэртээ Леонардо да Винчи “Үен тэвэрсэн хатагтай” зургаа Миланы гүнгийн амраг Сициллия Галлеранаг зурсантай холбоотой гэж урлаг судлаачид нэгэнт тогтоожээ. Эндээс бид ямар ч урсгал чиглэл, дүрслэл бай, амьдралын үнэн түүнийг танин мэдсэн туршлагын үр дүнд уран сайхны бүтээл болдог хөдөлшгүй үнэнг олж харж байна.

Бидний дээр дурдсан гурвалсан роман ямар онцлогтой вэ. Түүхийн үнэнийг танин мэдсэн, танин мэдсэн зүйлээ өөр өөрийн уран сайхны сэтгэлгээгээр илэрхийлсэн, илэрхийлсэн байдал нь монгол үндэстний язгуур эрх ашигт нийцсэн ингэхдээ өөр хоорондоо үл тохиролцон бичсэн нь цаг үе, нийгмийн шаардлагаар нэгдэн нийлж хүчтэй дуу хоолой болж өгсөнд байгаа юм.

Ж.Саруулбуянгийн “Хэрлэн тэнүүн” романд гол баатар Халхын Сэцэнхан аймаг, Сүжигт бээсийн хошууны их аварга, дууч Мөррэнчин, түүний дүү Жунай зааны дүрээр иргэд шашныг хэрхэн сүжиглэж хүлээн авч байсан, төр дээдсүүдтэй хэрхэн харьцаж байсныг тодорхой харуулсан. Ингэхдээ монголын түүх, соёлын хуудаснаа дурдагдаж байгаагүй бодит хүмүүсийн амьдралаар жишээлэн холбосон нь нэг талаас сонирхолтой, нөгөө талаар шинийг танин мэдүүлсэн ач холбогдолтой болжээ. Иргэдийн шашин сүсэг бишрэл түүнд хандах хандлага, хүлээж авч байдлыг “Майдарынд задын хувилгаан заларсан нь бүлэгт маш сонирхолтой үзүүлсэн байна. Зохиолд Майдарынх хүүтэй болоод хөл хөөрцөгтэйхөн дөрөв тав хонож байх үед нэгэн золбин нохой хээр оршуулсан шарилын царвуутай гар зууж ирээд угсраатай тэрэгнээс холгүйхэн хаячихсан байхыг Майдар үзээд ихэд сэжиглэн, гэрийхнээсээ тас нуун хол гэгч аваачиж хаяжээ. Тэр орой нь бяцхан хүү нь гэнэт час хийтэл уйлан гар хөл нь зэрэг татан бүх бие нь татвалзаж эхлэв. Хошуу хошуу алгасан бядан явдаг задын хувилгааныг Майдар шөнө дөлөөр хөтөлгөө морьтой эрж олон уулзаж, учир байдлаа хэлтэл жижгэвтэр мөнгөн аягатай хамар цоргих охь руу ямар нэгийг үглэн шившин үлээгээд: Майдар чи үүнээс нэг сайн балга. Очуутаа хүүгээ гайгүй сайн үлээчихээрэй. Харин өглөө хүүдээ

зүсэлсэн морь мал байвал бариад уячихаарай гэжээ. Майдар ч хувилгааны хэлснээр бүх зүйлийг гүйцэтгэсэн ба хүүдээ зүслүүлсэн халиун даагыг тэр шөнө чоно идсэн, Мядаг Майдарт цай аягалах үеэр гэр дүүрэн утаа суунаг татаж дарь үнэртсэн, хүү нь тайвширч унтсан зэрэг шашин, сүсэг бишрэлийн үйлүүд нь монголчуудын өдөр дутмын амьдралд хэвийн үзэгдэл байсныг сонирхолтойгоор үзүүлсэн байна. Тэгвэл жирийн иргэд, ардууд төртэйгээ хэрхэн харьцаж байсныг Гадаад хэргийн яамны сайд Чин ван Ханддоржтой уулзсан хэсгээс харж болно. Ханддорж вантан бөх шинжиж янз бүрийн хөдлөгөөн хийлгэж их л энгийнээр, ярьж хөөрч байхад хавь ойр байсан төр, шашны зүтгэлтнүүд ард иргэд үг үл дуугаран хүндэтгэн нэгэн ихэмсэг, тансаг орчинг бүрдүүлж байсан нь монголчуудын соёл, түүнийг эвтэй уртай үзүүлсэн зохиолчийн чадвар мөн юм. Их аварга Мөррэнчин сайн бөх төдийгүй сайн дууч, түүнийг түгээн дэлгэрүүлэгч, үе залгамжлан хадгалан хойшдын залуу үед дамжуулан өгдөг байсан нь зөвхөн энэ хүний хэрэг бус олон зуун жилийн турш нүүдэлчин монголчуудын дунд урлаг соёлын бүтээл хэрхэн уламжлагдан хадгалагдаж явж ирснийг товойлгон үзүүлсэн хэрэг. Зохиолд “За хүү минь чамайг хаанахын хэн гэдэг вэ гэхэд мөнөөх залуу;

- Жа, намайг Дамдины Сүх гэдэг. Сэцэнхан аймгийн Ёст бэйсийн хошууны харьяат. Эцэг маань ядуу учир амьдрахын эрхээр Хүрээнд ирээд би Амгаланбаатар хотод төрсөн юм. Аварга дуу сонсч байгаа юм шиг үл мэдэг хүзүүгээ гилжийлгэн анхааралтай сонсоод:

- Манай Сэцэнханы хүү байна. Сүх чиний хоолой эвтэйхэн дуугарч байна шүү. Сайн дуулахад амьсгаагаа зөв авах л чухал. Хэрвээ амьсгаагаа зөв авахгүй чихэлдүүлбэл мухар нүхэнд орсон тарвага шиг л хаашаа ч үгүй болно шүү гэхэд цэргүүд нир хийтэл инээлджээ.

Мөррэнчин аварга:

- Та нар Монголын баруун зүүн аймгуудаас ирсэн, олон газрын залуус байна. Нутаг нутгийнхаа дууг бол өөрсдөө эцэг эхээсээ яаж сурсан түүгээрээ дуулж явах ёстой. “Түмэн эх” гэдэг айзам урт дууг гэхэд л зүүн, баруун, төв, боржигин гээд янз янзын намба төрх, шуранхай, нугалгаа хугалгаа өөр өөрөөр дуулдаг. Боржигин “Түмэн эх” бол давхар дагнаалсан нарийн угалз хатган оёсон малгай шиг гоёмсог гэх үү дээ. Зүүн тал руугаа болохоор дуу их ханагар болоод явчих шиг байдаг. Баруун тал руугаа болохоор богино дуу, суман хэлбэртэй ч гэх үү дээ. Энэ нь газар нутгийнхаа уужим цэлгэр тал хээрийн байдлыг ч юм уу, уул хангай, хад чулуу ихтэйгээс ч юм уу болдог байж магадгүй болов уу гэж би ойлгож явдаг юм гэх мэтээр санаанд орсноо хэсэг яриад дахиад л мөнөөх зээгээ татуулж эхлэнэ. Зээгээ татуулахдаа өөрөө дагуулна. Аваргын зээ татах нь олон ямаан бүррэн дундаас нэг их бүрээний дуун онцгойрон уянгатай сонсдох шиг авай” гэсэн хэсэг бий. Энэ бол чухам бидний нандигнах хадгалах, сурах, үлдээх өв юм. Энэ бол өнөөдөр бидний урлаг уран сайханд тавих туурвил зүйн үнэ цэнэ юм.

Энэ мэт иргэн төр, иргэн шашин сүсэг бишрэл холбоо сүлбээ нь ардын дунд яаж шуухан амьдарч байсныг халхын хоёр их том бөхөөр төлөөллүүлэн үзүүлсэн нь нэг талаас амьдралыг танин мэдэх туршлага буюу зохиолчийн ертөнцийг үзэх үзэл хэрхэн боловсорсон, сэтгэлгээний ямар төвшинд байгааг харуулах нотолгоо нөгөө талаар тэр мэт баатраар дамжуулан тухайн цаг үеийн түүх домогт хүмүүсийн амьдралыг өнөөгийн олон нийтэд зарлан танилцуулсан шинэ мэдээллийн эх булаг болж байгаагаараа сонирхол татаж байгаа юм. Энэ тухай энэ цагийн бичгийн их хүн Л.Түдэв энэ мэтийн баримтат уран сайхны зохиолууд нь “харанхуй дундаас тэмтэрч олсон алтан үртэс” хэмээн үнэлсэн байдаг. Зохиолч халхын ах дүү хоёр том бөхийн дүрийг урлахдаа

зөвхөн бөх гэдэг талаас нь бус, сайн идтэй хүчтэй барилдаж байсан үеийг үзүүлж үзэл санаа, утга сэдвийг явцууруулсангүй, түүний ар гэр, найз нөхөд шашны хутагт хувилгаад, төрийн тэргүүдтэй харилцуулан өгүүлэмжийг баримт уран сайхнаар хослон сүлжилдүүлж үзүүлсэн нь чухамхүү нарийн бодсон зохиомжийн баталгаа болж өгчээ. Тиймээс ч бие биедээ эвлэн цэгцэрсэн өгүүлэмж зохиомж, баримт уран сайхны харьцаанд тухайн цаг үеийн төдийгүй ер монголчуудын язгуурын амьдралын гүн утга илэрснийг олон баримтаар нотолж хэлж болох байна. Бидний дээр дурдсан Чин ван Ханддоржтой бөхчүүд ард иргэд, төр шашны тэргүүтнүүдийн уулзалдааны үеэр нэгэн тансаг ихэмсэг орчин бүрэлдсэн нь ихэс дээдэс төрт ёсоо хүндлэх монголчуудын ёс заншлын нэгэн хэсэг болон харагдаж байгаа ч агуулгаараа төр шашин иргэний гурвалсан холбоо бие биенээ хүндэтгэж, бие биендээ уусан шингэж амар амгалан оршин тогтнож ирсэн олон жилийн түүх, одоо ч оршсоор байх бэлгэдэлт утгыг агуулснаараа бөхийн жудаг ёсыг гол эх болгож, монгол ахуй сэтгэлгээний өвөрмөц хөрсөн дээр дүрслэн үзүүлсэн дорно дахины соёлын хүн судлал, сэтгэл зүй, ёс зүй, зан заншлын өргөн холбоо уулзварыг чадамгай илэрхийлсэн дүрслэл болон үлдсэн байна.

Монгол хаад номын сан цувралаар ҮШ богд Жавзандамба хутагтын намтар, үйл ажиллагааг түүхчлэн үзүүлснээс өөрөөр шинэ цагт Богд хааны тухай, шашин төрийн үйл ажиллагаа, ард иргэдийн харилцаа хутагт хувилгаад, ханууд, гадаад дотоодын дээдэстэй хэрхэн харилцаж төр барьж байсан тухай дорвитой томоохон бүтээл гараагүй байсаар До.Цэнджавын “Цагаагчин гахай жил” романтай тулсан гэж хэлж болно. Дүрийн хувьд нэг дүрийг онцгойлон үзэж товойлгон, түүнийг тойруулан бусад үйл явдлыг сүлжилдүүлэн үзүүлдэг шинэ цагийн монгол романчдын арга барилаас зайлсхийж бүх дүрүүдийг ижил хэмжээнд аваачиж баримт уран сайхнаар шахан түүнийгээ харин 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын үйл хэрэгт төвлөрүүлсэн нь зургийн хэлээр монгол зурагтай адил бүх баримт, үйл явдал тов тодорхой, ойлгомжтой эн тэнцүү байгаа нь зохиолчийн найруулгын бас нэг онцлог гэж онцлон дурдмаар байна. Агуулгын бас нэг өвөрмөц талыг Богд хааныг шашны тэргүүн гэдэг утгаар бус төрийн тэргүүн гэдэг зангилаанд бүх өгүүлэмжийг татаж үүндээ Намнансүрэн, Чагдаржав, Ханддорж, Да лам нарын олон төр нийгэм шашны зүтгэлтнүүдийн үзэл бодлыг тэнцүү хэмжээтэйгээр хашин баримтаар дотоод утгыг дүүргэн уран сайхнаар гадаад илэрхийллийг дүрсэлсэн нь энэ цагт Эзэн Чингисээс улбаатай монгол төрийг захиран залж явсан их хаадын нэгээхний үйл хэргийг олон түмнээ өргөн дэлгэр, оновчтой тодорхойгоор гаргаж чадсанаар тайлбарлагдаж байна. Тухайлбал: Нэгэн удаа Богдын өргөөнд Да лам Цэрэнчимэд, хан Ханддорж, Чагдаржав, Хайсан нарын уулзалтаар туурга тусгаар эртний түүхт Чингисийн Монголоо байгуулья, Манжийн захиргааг хөөн зайлуулья, Богд хаант их монгол улсаа байгуулья гэсэн нэлээд ширүүн яриа өрнөхөд Богд хаан иймэрхүү яриа өрнөх, гарах байдлыг бүрэн мэдэж байсан, тэдгээр санаан дээр гадаад дотоодын хүчин зүйлийг тооцох ёстойг сануулан нэмж хэлээд тэдэнтэй санаа нэг байгаагаа илэрхийлж “та нар минь эхнээсээ хангир жингэр байж болохгүй ээ. Нэг үгийн хариуг өнөөдөр биш маргааш хэлж болно шүү дээ. Үүнийг өнгөрүүлж сурна гэдэг их чухал, үүгээрээ бол бид манж хятадаас доор шүү. Чингэс хаанаас хойшхи их бага хаадын маань сэлэм жад мохож бутраагүй, үгнээсээ болж бутарсан юм билээ” хэмээн айлдсан нь төрийн хар хайрцагны бодлогыг доод эрхэт түшмэдүүдээр хэлэлцүүлэн эцсийн зөв зүйтэй шийдвэрийг өөрөө нухацтай, болгоомжтой, үнэн зөв гаргадаг ухаантай, нухацтай, боловсролтой, сэрэмжтэй, өөрсдийн хаа байгаагаа зөв тооцоолж чаддаг, илүү дутуу, сайн ба муугаа мэддэг тэгш

удирдагчийн дүрийг уран сайхнаар чадварлаг үзүүлж чадсан хэрэг. Зохиолын нэг чухал санаа бол үндэсний эрх чөлөөний хувьсгал нь үнэхээр монгол орныг хамарсан том үйл хэрэг байсан түүнийг харин монгол орны өнцөг булан бүрт, ард иргэд нийтээр хүсэн хүлээж, дэмжин талархаж гагцхүү энэ агуу хүчин зүйл дээр монгол хан хаадууд дулдуйдаж хөдөлж их үйл хэргээ бүтээсэн юм гэдэг гаргалгааг гаргасан явдал болно. Энэ их үйл хэрэгт оролцсон Магсаржав, Бавуу гүн зэргийг орхигдуулаагүй бөгөөд зохиолч үүнээс өмнө тус тусад нь туужийн зохиол бичиж олноо хүргэснийг санахад зохиолын баримт, үйл явдлын судалгаа хэрхэн гүнзгий, бодтой, урт удаан цаг хугацааг хамарч хөдөлмөр орсныг харуулж байна.

“Хуучин тогтолцооны үед Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ шахуу үзэж, кино жүжгийг хүлээн авч байсан нь эдүгээ санахад хатуу цензур мэт боловч тэр хатуу мулгуу, хэт үзэл сурталжсан хяналтыг зөвхөн авъяастай зохиолч уран аргаар дийлэн гарч байсны нэгэн жишээ нь тухай үед магтах хориотой Богд гэгээний дүрийг кино урлагт ганцхан өгүүлбэрээр бүтээж, тэр хүний төрийн холч мэргэн бодлого богд их суурийг аварч гарсан “Өглөө” киноны нэгэн хэсэгт Богд хаан “Морин дэл дээр ертөнцийн талыг туулах амархан, мориноосоо буугаад төрийг төвхнүүлэх хэцүү” гэж өгүүлдэг нь дорнын номт төрийг барих, тэтгэх, сахих гэдэг гурван их ухаан, төрийг үүсгэн барих гэдэг нэг хэрэг, түүнээс илүү тэтгэх, сахихын дараалсан үйл урьд урьдахаасаа чухалтайг хэлсэн санаа” \Л.Хүрэлбаатар. Ашгийн доторхи зохиол, дүрийн гаднах хутагт. Дуун утгын яруу зохист. Улаанбаатар, 2005, 489-490-р тал\-г зохиолч До.Цэнджав бүрэн дэлгэрүүлэн ард олонтой нь, дайчин баатруудтай нь, ихэс дэдэстэй нь, гадаад дотоод нөхцөлтэй нь дэлгэрүүлэн олноо тавьсан нь утга урлаг соёлын үнэ цэнэ, өвийн асуудал яригдаж буй энэ үед цаг үеэ олсон үнэ цэнэтэй дуу хоолой гэж бат итгэлтэй хэлж байна.

Шинэ монголын урлаг соёл, уран зохиолын үнэт өв, үнэт зүйлсийн учир утгыг тогтоож өгч энэ талаар бичигч миний биеэс уран сайхны сэтгэлгээнд хашгаралт болсон гэж үзэж байгаа гуравдахь зохиол бол яруу найрагч Г.Мэнд-Оёогийн “Тэгээнтэн” роман юм. Их соён гэгээрүүлэгч, шашны томоохон зүтгэлтэн Равжаагийн талаар шинжлэх ухааны болон уран сайхны олон бүтээл туурвил гарсан. Эрдэм шинжилгээний хувьд Равжаагийн бүтээлийн өөр хүний бүтээл болгон тайлбарласан эрдэм шинжилгээний зохиолууд гарсан нь оюутан суралцагч, сонирхон уншигч нар эргэлзээнд хүрсэн. Уран сайхны бүтээлийн хүрээнд Б.Догмидын зохиож, И.Нямгаваагийн найруулсан “Догшин хутагтын сахиус” кинонд Равжаа хутагтын дүрийг уран сайхнаар амилуулах хэмээсэн их зорилгын давааны бэлд нь эцэж, “догшин”, “галзуу”, “согтуу”, “солиот”, “гайхал” гэсэн нэрний нь буданд төөрч, хойшоо яваад гэртээ түргэн хүрэхээр гарсан атал урагшаа яваад гэрээсээ төдий холдсон мэт болжээ. Хатуу тарнийн бясалгалын чадлаараа “догшин”, хамгаас хурааж сэтгэлийг төвлөрүүлэн, бясалгалын агаарт оршоноороо “согтуу”, харин хамаг нийтийн сэтгэлийн “галзуугийн” үзэгдэлд “эрүүл” дүрийг бүтээх ёстой байтал “Мал аа!” хэмээн номын шавь нараа хашгичин загнасан, Халхын Их хүрээнийхээ хамба ламын халуун гал голомтыг самран, хөөтэй хар тулгыг нь шүүрч авч толгой тэргүүнд нь угласан, нас залуу охины хөхнөөс ертөнцийн хуял хурыцлын харанхуй шуналаар “нүд анин” зуурсан тийм авир араншин, ажил явдалтай номын хутагтыг харуулаад их номчийн дүрийг, их соён гэгээрүүлэгчийн дүрийг бүтээсэн хэмээн сэтгэх нь царцааны дуу тэнгэрт хүрдэггүйтэй үлгэр нэг хэрэг болно.” \Л.Хүрэлбаатар, Ашгийн доторхи зохиол, дүрийн гаднах хутагт. Дуун утгын яруу зохист. Улаанбаатар, 2005, 496-р тал\ гэсэн иймэрхүү ойлголттой өнөөг хүрч ирлээ.

Харин “Гэгээнтэн” хэмээх роман гарснаар дээр дурдсан утга учиргүй зүйлд нэгмөсөн хариулт өгөх, Равжаагийн дотоод чинадын нууцад уран сайхнаар нэвтрэн, ид шид хувилгаан чанарын мөн чанарыг тайлбарлан таниулах, ингэснээрээ шашны зан үйл, иргэний ёс заншлын холбоо уялдааг харуулах, хариулахын цаана танин мэдүүлэх, өнгөрснийг нээн сануулах их утга учрыг агуулжээ.

Роман гарсны дараагаар шүүмжлэгч Ч.Билигсайхан “*Үнэний төгөлдөр дуулал-Гэгээнтэн*” хэмээх шүүмждээ туурвил зүйн үүднээс ажиглалт задлан шинжлэл хийж уран сайхны хувьд баримтад тулгуурлан, буддизмын онолын тулгуур үзэл баримтлалуудыг багтаасан домгуудад түшиглэсэн, урд өмнө олон нийтэд хүртээл болж байгаагүй сонин содон баримтуудыг ашигласан Равжаагийн дотны хүн Дадишурагийн дүрийг уран сайхнаар нэгмөсөн шийдэж өгсөн зэрэг үнэлэлтүүдийг өгсөн байх тул миний бие чухам ямар зүйлд ач холбогдол өгч байгаагаа давхардуулалгүй хэлье гэж бодож байна.

Өнөөгийн бараг хүн бүрийн хандах болсон бясалгалын мөн чанарыг хоёр зууны тэртээ Равжаа хутагт ойлгон ухаарч, туршин нэвтрүүлж, үүнийгээ шашин номын хүчинд дулдуйдаж, ард иргэдэд ойртуулан холбож өгч байсан агуу оюуны хүчийг гаргаж өгсөн ач холбогдолтой зохиол юм. Тодруулан хэлбэл хүний биед өөрийгөө хамгаалах, хийж бүтээх сүйтгэх хүчин чадалтай асар их энерги байдаг ажээ. Эдгээр асар их хүчтэй энергийн нэг бол хүсэл тачаал бөгөөд, хүсэл тачаалын оргил төгсгөлд хуримтлагдсан тэрхүү энергийг номын бясалгал, яруу найраг туурвих болон бусад үйлд зориулан оюун ухаан сэтгэхүйн хүчээр өөрчлөн ашиглах бясалгалын ид шидийг үзүүлж байсан гайхамшигт чанарыг илрүүлэн гаргахыг оролдсон нь үнэхээр сайшаалтай байна. Зохиолд энэ тухай “Дадишурагийн тунгалаг цагаан царай сарны гэрэлд гүмүда цэцгийн дэлбээ нээсэн цоморлиг мэт мөшөөж, урьд хэзээ ч үнэрлээгүй, зохис тааламжит анхилан нь Хутагтын сэтгэлийг ер бусаар оргилуулан хөдөлгөөд зөвхөн егүзэрийн бясалгалаар мэдэх тэр таашаалаас огт өөрөөр хайр хүслэн нь ивэлжээ. Дадишурагийн бэлхүүсийн торгомсог, гарынх нь уян налархайг ямар ч яруу шүлэг дуулалд бичихүйеэ үг дутмаар. Яагаад ч юм яг энэ чигээрээ хүслийн мананд согтууран живээд, улаан шар хувцас, сүм хийд бүгдийг орхин, зөвхөн Дадишурагаа аваад говийнхоо бударганат талд гэр бариад эгэл хар хүмүүний амьдралаар одсугай хэмээн гэнэт бодогдоод түүний уруулын балын амтанд зөгий мэт шунган тэмүүлэх үесэд... Дүйнхорын хот мандал сэтгэлд нь урган, эрхгүйеэ эгэлийн хүлээсийг тайлуулан бурхадын тигд хөтөлбэй... Од мичид хад чулуу бүгдээр номын агаарт уусан алдраад Ноён хутагт Дадишура хоёр янаглал амраглалаас хэтийдэн хүмүүн биеийг нэгэнт мартаад, оюун бодлоос ч аль хэдийн ангижран дотоод чинадын аглагтаа дүүлвээ” хэмээсэн нь ёстой л Равжаагийн дотоод мөн чанарыг таних, ухан ойлгох гол түлхүүрүүдийн нэг болж өнгөн дээрээ янаг амраг, завхай зайдан мэт дүрслэн ачир дээрээ биднээс хэдэн арван жил түрүүлэн бясалгалын хүчээр бие сэтгэлийг эзэмдэн жолоодох агуу том сургуулийг хийж байсны нотолгоо юм. Чухам энэ агуулгаараа “Гэгээнтэн” роман нь урьд өмнө гарч байсан судалгаа шинжилгээний болон уран сайхны бүтээлүүдээс эрс ялгарч, түүгээр үл барам иргэн төвтэй “Хэрлэн тэнүүн”, төр төвтэй “Цагаагчин гахай жил” зохиолуудтай хамсран шашин сүсэг бишрэлийг улаан шугам болгон иргэн төр шашны гурвалсан холбоонд өөр өөрийн хувь онцлогийг гаргахын зэрэгцээ, эргэн нэгдэж монгол нүүдэлчдийн язгуурын соёл иргэншлийн томоохон толь болон гялалзаж байна.

Өгүүллийн эхэнд дурдсан Готтфрид Лейбницийн туршлага дээр тулгуурлан баримтын үнэн гардаг тухай гаргалгаа нь хоорондоо үгсэн тохироогүй ч өнөөдөр

бидний амьдралын хэмнэл, түүнд хандах нийгэм сэтгэл зүйн хандлага, цаг үеийн тохироо нь төр шашин иргэнийг тус тусдаа, тусдаа мөртлөө хамтдаа илэрхийлсэн гурван зохиолчийн гурван бүтээл нь намтар түүх, домог, ардын уламжлалын судлалд дулдуйдсан, аль нэг үзэлд баригдалгүй, хэтийдүүлэн гүжирдэх буюу өргөн магтаагүй, үзэгдэл мөн чанарын ерөнхий ба тусгайн харьцаанд тааруулан шахаж, шалтгаан түүний үр дагаврыг учир зүйн дарааллын дагуу өрнүүлсэн эдгээр нь эргээд өнөөдөр бидэнд нүүдэлчдийн соёлын өвөрмөц үнэт зүйлсийг ойлгож хүлээн авах томоохон цочроог өгсөн туурвилууд болжээ гэж хэлмээр байна.

Энэ бол их сайны эхлэл юм аа.